



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/227

Ховд

Төслийн дэд хороо шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.5-ын "А" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хөнгөлттэй зээлээр хэрэгжүүлж буй "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн үйл ажиллагаанд орон нутагт дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих чиг үүрэг бүхийн төслийн дэд хороог дараах бүрэлдхүүнтэй байгуулсугай.

- Дэд хорооны ахлагч: -Аймгийн Засаг даргын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч
- Гишүүд:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
  - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
  - Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
  - Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
  - Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга
  - Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
  - Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга
  - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

-Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын нарийн бичгийн дарга

-Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн

-Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны зохицуулагч

Нарийн бичгийн  
Дарга

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн

2.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч /Т.Дэлгэрсайхан/-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/677 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ